| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | 66,146,600.00         | 57,787,464.91 | 8,359,135.09   | 87.36  |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                            | 66,146,600.00         | 57,787,464.91 | 8,359,135.09   | 87.36  |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | 65,346,600.00         | 57,067,464.91 | 8,279,135.09   | 87.33  |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | 48,417,800.00         | 43,057,365.17 | 5,360,434.83   | 88.93  |
| 210101                | Үндсэн цалин                                                    | 44,278,800.00         | 40,499,095.67 | 3,779,704.33   | 91.46  |
| 210102                | Нэмэгдэл                                                        | 4,139,000.00          | 689,296.55    | 3,449,703.45   | 16.65  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                           |                       | 1,624,000.00  | (1,624,000.00) | -      |
| 210104                | Урамшуулал                                                      |                       | 244,972.95    | (244,972.95)   | -      |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | 6,536,400.00          | 5,382,170.74  | 1,154,229.26   | 82.34  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                              | 4,599,700.00          | 3,398,806.55  | 1,200,893.45   | 73.89  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                              | 484,200.00            | 660,929.16    | (176,729.16)   | 136.50 |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                               | 387,300.00            | 350,601.73    | 36,698.27      | 90.52  |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                            | 96,800.00             | 104,543.15    | (7,743.15)     | 108.00 |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                           | 968,400.00            | 867,290.15    | 101,109.85     | 89.56  |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | 2,538,000.00          | 1,851,454.00  | 686,546.00     | 72.95  |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                                | 525,000.00            | 851,454.00    | (326,454.00)   | 162.18 |
| 210302                | Түлш, халаалт                                                   | 2,013,000.00          | 1,000,000.00  | 1,013,000.00   | 49.68  |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | 5,302,400.00          | 4,982,400.00  | 320,000.00     | 93.96  |
| 210401                | Бичиг хэрэг                                                     | 337,400.00            | 337,400.00    | -              | 100.00 |
| 210402                | Тээвэр, шатахуун                                                | 4,520,000.00          | 4,520,000.00  | -              | 100.00 |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 445,000.00            | 125,000.00    | 320,000.00     | 28.09  |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | 1,053,600.00          | 386,000.00    | 667,600.00     | 36.64  |
| 210604                | Урсгал засвар                                                   | 1,053,600.00          | 386,000.00    | 667,600.00     | 36.64  |
| <b>2107</b>           | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | 1,146,400.00          | 1,134,000.00  | 12,400.00      | 98.92  |
| 210702                | Дотоод албан томилолт                                           | 1,146,400.00          | 1,134,000.00  | 12,400.00      | 98.92  |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 352,000.00            | 274,075.00    | 77,925.00      | 77.86  |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                        | 100,000.00            | 100,000.00    | -              | 100.00 |
| 210803                | Даатгалын үйлчилгээ                                             | 146,600.00            | 81,675.00     | 64,925.00      | 55.71  |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 55,900.00             | 51,400.00     | 4,500.00       | 91.95  |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                   | 49,500.00             | 41,000.00     | 8,500.00       | 82.83  |
| <b>213</b>            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                         | 800,000.00            | 720,000.00    | 80,000.00      | 90.00  |
| <b>2132</b>           | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | 800,000.00            | 720,000.00    | 80,000.00      | 90.00  |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                         | 800,000.00            | 720,000.00    | 80,000.00      | 90.00  |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | 66,146,600.00         | 66,146,600.00 | -              | 100.00 |
| <b>1320</b>           | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 66,146,600.00         | 66,146,600.00 | -              | 100.00 |
| 132001                | Орон нутгийн төсвөөс                                            | 66,146,600.00         | 66,146,600.00 | -              | 100.00 |
| <b>62</b>             | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                                          | 5.00                  | 5.00          | -              | 100.00 |
| 620001                | Удирдах ажилтан                                                 | 1.00                  | 1.00          | -              | 100.00 |
| 620002                | Гүйцэтгэх ажилтан                                               | 4.00                  | 4.00          | -              | 100.00 |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн анги нь эрхэм зорилгоо “Ойн баялгийн нөөцийг тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,656.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                   | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт          |
|--------------------------------------------|-------------------|--------------------|-------------------|
| Б                                          | 1                 | 2                  | 3=2-1             |
| Мөнгөн хөрөнгө                             | -                 | -                  | -                 |
| Авлага                                     | 200.5             | 200.5              | -                 |
| Бараа материал                             | 30,530.3          | 31,946.3           | 1,416.0           |
| Үндсэн хөрөнгө                             | 133,352.8         | 121,696.7          | (11,656.1)        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                  | <b>164,083.6</b>  | <b>153,843.5</b>   | <b>(10,240.1)</b> |
| Өглөг                                      | 36.3              | 66.3               | 30.0              |
| Засгийн газрын хувь оролцоо                | 100,000.0         | 100,000.0          | -                 |
| Хуримтлагдсан үр дүн                       | 64,047.3          | 53,777.2           | (10,270.1)        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>164,083.6</b>  | <b>153,843.5</b>   | <b>(10,240.1)</b> |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,416.0 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,656.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 66,146.6 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 66,146.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 66,146.6 төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 57,787.5 мянган төгрөгийг зарцуулж, 8,359.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 57,787.5 мянган төгрөг буюу 87,4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5,360.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 686.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 320.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 667.6 мянган төгрөг, томилолт, зочны зардал 12.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 77.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 80.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д        | Хөтөлбөр, арга хэмжээ                                   | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       | Зөрүү          | Биелэлт     |
|------------|---------------------------------------------------------|-----------------|-----------------|----------------|-------------|
| 1          | 71403-Ойжуулалт                                         |                 |                 |                |             |
| 1.1        | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал                     | 65,346.6        | 57,067.5        | 8,279.1        | 87.3        |
| 1.2        | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 800.0           | 720.0           | 80.0           | 90.0        |
| <b>Дүн</b> |                                                         | <b>66,146.6</b> | <b>57,787.5</b> | <b>8,359.1</b> | <b>87.4</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулах, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 66,146.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 992.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5,360.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 686.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 320.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 667.6 мянган төгрөг, томилолт, зочны зардал 12.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 77.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 80.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 161 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 131 мэдээллийг хугацаандаа, 30 мэдээллийг хугацаа хоцроосон нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 13,474.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,660.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснийг 6,220.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 440.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарч байна. Хэрэгжилт 75 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт  |                 |              |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо      | Дүн             | Хувь         |
| Албан шаардлага | 1                      | 44,349.3        | 1        | 44,349.3        | 100.0        |
| Төлбөрийн акт   | 1                      | 38.0            | 1        | 38.0            | 100.0        |
| Зөвлөмж         | 2                      | 3,808.3         | 2        | 3,808.3         | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>4</b>               | <b>48,195.5</b> | <b>4</b> | <b>48,195.5</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.



## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 563.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 563.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

### **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчил илрээгүй.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлага, өглөгийн данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Өмнөх онд үүссэн ажиллагсадтай холбоотой он дамжсан 200.5 мянган төгрөгийн авлага, 36.3 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Он дамжсан авлага, өр төлбөрийг даруй барагдуулах.

#### **2. Зардлын данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Тайлант онд төсвийг бодитой төлөвлөөгүйгээс гэрэл цахилгааны зардлыг 326.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                           | Нийт зөрчил |              | Үүнээс        |     |                 |     |          |              |                                      |                     |                                                  |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------|---------------|-----|-----------------|-----|----------|--------------|--------------------------------------|---------------------|--------------------------------------------------|-----|
|                                                                                                                                              |             |              | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |              | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал |     |
|                                                                                                                                              | Тоо         | Дүн          | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн          | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                              | Дүн |
| Өмнөх онд үүссэн ажиллагсадтай холбоотой он дамжсан 200.5 мянган төгрөгийн авлага, 36.3 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд барагдуулаагүй | 1           | 236.8        | -             | -   | -               | -   | 1        | 236.8        | -                                    | -                   | -                                                | -   |
| Тайлант онд төсвийг бодитой төлөвлөөгүйгээс гэрэл цахилгааны зардлыг 326.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан                             | 1           | 326.4        | -             | -   | -               | -   | 1        | 326.4        | -                                    | -                   | -                                                | -   |
| <b>Дүн</b>                                                                                                                                   | <b>2</b>    | <b>563.2</b> | -             | -   | -               | -   | <b>2</b> | <b>563.2</b> | -                                    | -                   | -                                                | -   |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |          |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|----------|-----|
|                                                                                                          |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |          |     |
|                                                                                                          | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо      | Дүн |
| <u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>                                          |             |     |               |     |                 |     |         |     |          |     |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 131 мэдээллийг хугацаандаа, 30 мэдээллийг хугацаа хоцроосон | 1           | -   | -             | -   | -               | -   | -       | -   | 1        | -   |
| <b>Дүн</b>                                                                                               | <b>1</b>    | -   | -             | -   | -               | -   | -       | -   | <b>1</b> | -   |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)